

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв, Өмнөд, Зүүн, Баруун, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхийн цахилгаан түгээх сүлжээнээс худалдан авсан цахилгааны төлбөрөөс суутган тооцож ажиллахыг цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

5. Энэ тогтоол “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 390 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

----- ГАРЫН ҮСЭГ -----

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны 12 дугаар сарын ... -ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ХЭРЭГЛЭГЧИЙН СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮҮСГҮҮРЭЭС ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД НИЙЛҮҮЛСЭН ЦАХИЛГААНЫ ТАРИФ

1. Төв, Зүүн, Өмнөд, Баруун, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага			
1	Өдрийн хэрэглээ (06:00-17:00)	төг/кВт.ц	220.00
2	Оройн хэрэглээ (17:00-22:00)	төг/кВт.ц	300.00
Айл, өрх			
1	Өдрийн хэрэглээ (06:00-17:00)	төг/кВт.ц	220.00
2	Оройн хэрэглээ (17:00-21:00)	төг/кВт.ц	300.00